

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил .....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан.....	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/307  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга Ц.Дуламсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 04-ний өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК-ийн аудитор Д.Дондог хариуцаж хэрэгжүүлэв.

Богд Хан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дугаар сарын 25-ны өдрийн А/95 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Богд Хан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь Богдхан уулын байгалийн унаган төрхийг хадгалж, ургамал амьтны аймгийг хамгаалах, өсгөн үржүүлэх, ан амьтныг нутагшуулах, хойч үедээ өвлүүлэн үлдээх, Байгаль орчныг хамгаалах бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Богдхан уулын байгалийн унаган төрх, ургамал амьтны аймгийг хамгаалах, өсгөн үржүүлэх, ан амьтаныг нутагшуулах үйл ажиллагаа явуулна.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Байгаль орчны тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны хувьд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул томилогдсон баг аудитыг гүйцэтгэлээ.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тухайн байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц гэж үзсэнтэй холбоотой юм.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 649,416.1 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 12,988.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2 хувиар тооцсон нь эрсдэл багатай гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

				/мянган төгрөгөөр/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	33,100.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1,323.0	
	Дүн	2	34,423.0	

## **2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### **2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал**

Захиргааны хэлтсийн 9 ажилтанд амралтын мөнгө олгоходоо хоол унааны мөнгө 1,323.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 2 дугаар хавсралт "Ээлжийн амралтын олговор тооцох журам" Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам" тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох.

### **2.8.1.2 Балансын данстай холбоотой асуудал**

Мөнгөн хөрөнгийн 20,828.0 мянган төгрөгийн 2018 оны эхний үлдэгдэл баталгаажуулахгүй, /Үүний 10,780.0 мянган төгрөг нь 2017 оны 11 сарын 09-ны өдөр Эрүүгийн цагдаагийн байгууллагад хураагдсан ба одоогийн байдлаар шийдвэрлээгүй, 10,000.0 мянган төгрөг нь нярав Н.Баярсайханы хувийн хадгаламж, 48.0 мянган төгрөг нь дансны бичилтийн зөрүү байсан гэх/ Дээрх үлдэгдлийг холбогдох тушаал шийдвэргүйгээр найдваргүй авлагын зардалд хаасан байна

Шийдвэрлэсэн:

Тайлант хугацаанд залруулсан.

## **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Цалингийн зардал дээр амралтын мөнгөний тооцоолол зассан эсэх, бараа материалын дансны анхан шатны баримтын бүрдэл, авлагын дансанд авлага барагдуулах арга хэмжээ авч ажилласан талаар үзнэ. Анхаарал татахуйц бусад чухал асуудал үгүй байна.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 381,088.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 379,554.1 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь Бараа ажил үйлчилгээний зардал нийт 1,534.7 мянган төгрөгөөр хэмнэсэн ба үүнд цалин хөлсний

зардал 192.5 мянга, байр ашиглалтын зардал 75.2 мянга, урсгал засварын зардал 67.0 мянга, хангамж, бараа материалын зардал 58.1 мянга, бусад урсгал зардал 80.1 мянга, томилолтын зардал 15.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 1,046.0 мянган төгрөг тус тус хэмнэсэн байна. Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас олох орлогоо 1,000.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь нөхөн сэргээлтийн төлбөрийн орлого нэмэгдсэнтэй холбоотой.

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж үзэхэд үүргийн биелэлтийг хангалттай гэж дүгнэсэн ба 2018 онд сар тутам тайлан мэдээг оруулсан, улирлын тайлан мэдээг хугацаандаа шивж оруулсаныг баримтжуулсан болно.

### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Зөвшөөрөлгүй барьсан барилгыг буулгахад 33,100.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Хан-Уул дүүргийн Засаг даргын 2018 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/138 тоот захирамжинд "Газар чөлөөлөх албадан нүүлгэхэд холбогдох зардлыг буруутай этгээдээр төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна. Энэ нь Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/93 дугаартай "Хөрөнгө гаргах, тушаалын хэрэгжилтийг хангуулах тухай" тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Зардлыг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулсан байх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Холбогдох тушаал, захирамжийг мөрдлөг болгон ажиллаж, шүүхийн шийдвэрийг гаргуулан холбогдох этгээдээр зардлыг нөхөн төлүүлж улсын төсөвт төвлөрүүлэх.

Дээрх аудитаар илэрсэн зөрчлүүдтэй холбоотойгоор дотоод хяналтыг цаашид сайжруулах шаардлагатай байна.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Дээрх зардалтай хобоотой асуудал шүүхийн шатанд шийдвэрлэгдээгүй байгаа бөгөөд шийдвэр гарсан үед зөвлөмжийн дагуу ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

#### 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>111,752,867.75</u></b>	<b><u>101,620,462.15</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	20,828,000.00	00.00
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	20,828,000.00	00.00
31110	Төгрөг	20,828,000.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	20,828,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	20,828,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	20,828,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	90,924,867.75	80,792,462.15
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	68,124,867.75	57,642,462.15
35410	Бичиг хэргийн материал	4,250,200.00	4,649,454.00
35420	Аж ахуйн материал	10,096,855.20	8,764,824.20
35440	Түлш, шатах тослох материал	3,843,500.00	908,500.00
35470	Бусад хангамжийн материал	49,934,312.55	43,319,683.95
35500	Биологийн хөрөнгө	22,100,000.00	
35600	Мал амьтад	700,000.00	23,150,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>405,036,272.27</u></b>	<b><u>616,300,302.07</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	405,036,272.27	616,300,302.07
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	405,036,272.27	356,354,302.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	429,780,954.30	222,027,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-120,653,448.18	-8,992,749.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	144,217,250.00	125,687,250.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-90,239,885.61	-90,400,447.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,498,088.29	74,112,540.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,559,047.52	-32,760,410.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,833,375.83	14,366,284.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,841,014.84	-4,052,415.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,028,000.00	74,244,694.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,028,000.00	-17,877,444.50
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	259,946,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	259,946,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>516,789,140.02</u></b>	<b><u>717,920,764.22</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>516,789,140.02</u></b>	<b><u>717,920,764.22</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	516,789,140.02	717,920,764.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	461,573,092.36	721,519,092.36
51101	Өмч: - төрийн	461,573,092.36	721,519,092.36
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	32,461,496.97	-29,387,543.16
51210	Өмнөх үеийн үр дүн	32,461,496.97	32,461,496.97
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-61,849,040.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,754,550.69	25,789,215.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>516,789,140.02</u></b>	<b><u>717,920,764.22</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>617,474,490.74</b>	<b>566,739,084.72</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>191,595,960.74</b>	<b>52,015,284.72</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	191,595,960.74	52,015,284.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	191,595,960.74	50,065,284.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,100,000.00	21,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	49,728,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	126,767,960.74	29,065,284.72
120009	Бусад орлого	00.00	1,950,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>425,878,530.00</b>	<b>514,723,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	339,985,100.00	361,088,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	339,985,100.00	361,088,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	85,893,430.00	153,635,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,480,000.00	48,560,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	56,413,430.00	105,075,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	717,920,764.22
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>552,640,786.69</b>	<b>576,412,548.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>552,640,786.69</b>	<b>576,412,548.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	549,451,805.87	496,188,568.66
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	294,695,046.80	281,890,657.62
210101	Үндсэн цалин	294,612,546.80	209,801,057.62
210102	Нэмэгдэл	00.00	53,081,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	82,500.00	19,008,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,808,452.53	33,745,600.00
210201	Тэтгэврийн даатгал	20,884,522.89	22,499,523.68
210202	Тэтгэмжийн даатгал	2,974,135.97	2,811,519.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,446,632.37	2,249,215.06
210204	Ажилгүйдлийн даатгал	591,196.48	562,303.52
210205	Эрүүл мэндийн даатгал	5,911,964.82	5,623,038.16
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,225,759.14	5,089,556.77
210301	Гэрэл, цахилгаан	2,126,110.60	2,723,456.77
210302	Түлш, халаалт	2,298,400.08	1,953,600.00
210303	Цэвэр, бохир ус	801,248.46	412,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	35,813,069.19	37,749,981.11
210401	Бичиг хэрэг	7,993,868.00	5,807,746.00
210402	Тээвэр, шатахуун	10,868,611.00	12,860,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,737,263.71	1,786,105.51
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,536,100.00	8,943,563.60
210408	Бараа материал акталсны зардал	12,677,226.48	8,352,566.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	24,113,575.35	00.00

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны  
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,113,575.35	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,180,000.00	621,000.00
210604	Урсгал засвар	1,180,000.00	621,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,924,000.00	3,654,000.00
210702	Дотоод албан томилолт	9,924,000.00	3,654,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	89,571,416.00	69,855,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,397,389.00	66,858,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	226,080.00	812,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	282,947.00	799,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	185,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	56,120,486.86	63,582,773.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,236,000.00	9,678,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,884,486.86	53,904,573.16
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,188,980.82	230,558,456.84
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	00.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	-61,849,040.13
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	33,888,234.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	717,920,764.22
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	33,888,234.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,188,980.82	46,335,746.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,188,980.82	46,335,746.10
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>64,833,704.05</u></b>	<b><u>-9,673,464.04</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	36,586,110.19	52,175,576.09
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	28,536,110.19	250,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,050,000.00	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	51,925,576.09
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-36,586,110.19	-52,175,576.09
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>28,247,593.86</u></b>	<b><u>-61,849,040.13</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>495,606,530.00</b>	<b>535,723,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>69,728,000.00</b>	<b>21,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	69,728,000.00	21,000,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	69,728,000.00	21,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	21,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	49,728,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>425,878,530.00</b>	<b>514,723,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	339,985,100.00	361,088,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	339,985,100.00	361,088,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	85,893,430.00	153,635,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,480,000.00	48,560,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	56,413,430.00	105,075,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>474,778,530.00</b>	<b>530,561,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>474,778,530.00</b>	<b>530,561,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>461,100,049.18</b>	<b>450,337,819.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	284,469,615.77	281,890,657.62
210101	Үндсэн цалин	195,679,331.77	209,801,057.62
210102	Нэмэгдэл	54,740,000.00	53,081,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,098,000.00	19,008,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,952,284.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,544,383.56	33,745,600.00
210201	Тэтгэврийн даатгал	22,062,008.41	22,328,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,183,154.72	2,854,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,649,744.93	2,283,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	513,588.68	570,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,135,886.82	5,708,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,197,759.14	5,089,556.77
210301	Гэрэл, цахилгаан	3,098,110.60	2,723,456.77
210302	Түлш, халаалт	2,298,400.08	1,376,100.00
210303	Цэвэр, бохир ус	801,248.46	990,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,470,874.71	23,474,005.51
210401	Бичиг хэрэг	3,558,000.00	5,277,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,490,611.00	9,925,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,017,263.71	2,016,105.51
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	605,000.00	6,255,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,800,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	594,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	594,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,092,000.00	1,121,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,200,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	712,000.00	00.00

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны  
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	1,180,000.00	1,121,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,924,000.00	3,654,000.00
210702	Дотоод албан томилолт	9,924,000.00	3,654,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	91,571,416.00	101,363,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,397,389.00	77,538,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	226,080.00	812,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	282,947.00	799,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	185,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,236,000.00	20,828,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,236,000.00	20,828,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,678,480.82</b>	<b>80,223,980.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,489,500.00	33,888,234.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	33,888,234.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,489,500.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,188,980.82	46,335,746.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,188,980.82	46,335,746.10
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>20,828,000.00</u></b>	<b><u>5,162,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>46,818,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>46,818,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	46,818,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	25,990,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>-25,990,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	20,828,000.00	-20,828,000.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	20,828,000.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	20,828,000.00	00.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	461,573,092.36	22,754,550.69	4,213,903.11	488,541,546.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>461,573,092.36</b>	<b>22,754,550.69</b>	<b>4,213,903.11</b>	488,541,546.16
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	28,247,593.86	28,247,593.86
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>461,573,092.36</b>	<b>22,754,550.69</b>	<b>32,461,496.97</b>	516,789,140.02
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>461,573,092.36</b>	<b>22,754,550.69</b>	<b>32,461,496.97</b>	516,789,140.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>461,573,092.36</b>	<b>22,754,550.69</b>	<b>32,461,496.97</b>	516,789,140.02
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	3,034,664.33	-	3,034,664.33
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	259,946,000.00	-	-	259,946,000.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-61,849,040.13	-61,849,040.13
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>721,519,092.36</b>	<b>25,789,215.02</b>	<b>-29,387,543.16</b>	<b>717,920,764.22</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	381,088,800.00	379,554,053.90	-1,534,746.10	99.6
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	381,088,800.00	379,554,053.90	-1,534,746.10	99.6
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	347,120,500.00	345,665,819.90	-1,454,680.10	99.6
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	281,213,200.00	281,020,657.62	-192,542.38	99.9
Үндсэн цалин	209,123,600.00	208,931,057.62	-192,542.38	99.9
Нэмэгдэл	53,081,600.00	53,081,600.00	-	100
Унаа хоолны хөнгөлөлт	19,008,000.00	19,008,000.00	-	100
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,745,600.00	33,745,600.00	-	100
Тэтгэврийн даатгал	22,328,200.00	22,328,200.00	-	100
Тэтгэмжийн даатгал	2,854,400.00	2,854,400.00	-	100
ҮОМШӨ-ний даатгал	2,283,400.00	2,283,400.00	-	100
Ажилгүйдлийн даатгал	570,900.00	570,900.00	-	100
Эрүүл мэндийн даатгал	5,708,700.00	5,708,700.00	-	100
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,164,800.00	5,089,556.77	-75,243.23	98.5
Гэрэл, цахилгаан	2,798,700.00	2,723,456.77	-75,243.23	97.3
Түлш, халаалт	1,376,100.00	1,376,100.00	-	100
Цэвэр, бохир ус	990,000.00	990,000.00	-	100
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,532,100.00	13,474,005.51	-58,094.49	99.6
Бичиг хэрэг	1,783,600.00	1,777,000.00	-6,600.00	99.6
Тээвэр, шатахуун	7,928,800.00	7,925,000.00	-3,800.00	100
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,019,600.00	2,016,105.51	-3,494.49	99.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,100.00	1,755,900.00	-44,200.00	97.5
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,188,000.00	1,121,000.00	-67,000.00	94.4
Урсгал засвар	1,188,000.00	1,121,000.00	-67,000.00	94.4
<b>Томилолт, зочны зардал</b>	3,669,800.00	3,654,000.00	-15,800.00	99.6
Дотоод албан томилолт	3,669,800.00	3,654,000.00	-15,800.00	99.6
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,607,000.00	7,561,000.00	-1,046,000.00	87.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,610,000.00	4,564,000.00	-1,046,000.00	81.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	1,200,000.00	-	100
Даатгалын үйлчилгээ	812,000.00	812,000.00	-	100
Тээврийн хэрэгслийн татвар	799,900.00	799,900.00	-	100
Тээврийн хэрэгслийн оношлогоо	185,100.00	185,100.00	-	100
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	33,968,300.00	33,888,234.00	-80,066.00	99.8
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	33,968,300.00	33,888,234.00	-80,066.00	99.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,968,300.00	33,888,234.00	-80,066.00	99.8
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	381,088,800.00	382,088,800.00	1,000,000.00	100
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	361,088,800.00	361,088,800.00	-	100

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны  
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улсын төсвөөс санхүүжих	361,088,800.00	361,088,800.00	-	100
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	20,000,000.00	21,000,000.00	1,000,000.00	105
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	21,000,000.00	1,000,000.00	105
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	20,828,000.00	20,828,000.00	
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	35.00	35.00	-	100
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100
Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	-	100
Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>34.00</b>	<b>34.00</b>	-	100

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>155,495,000.00</b>	<b>109,834,000.00</b>	<b>45,661,000.00</b>	<b>70.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>155,495,000.00</b>	<b>109,834,000.00</b>	<b>45,661,000.00</b>	<b>70.6</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	155,495,000.00	109,834,000.00	<b>45,661,000.00</b>	70.6
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	870,000.00	870,000.00		100
Үндсэн цалин	870,000.00	870,000.00		100
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,000,000.00	10,000,000.00		100
Бичиг хэрэг	3,500,000.00	3,500,000.00		100
Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00		100
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00	4,500,000.00		100
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	144,625,000.00	98,964,000.00	45,661,000.00	68.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,625,000.00	98,964,000.00	45,661,000.00	68.4
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-		100
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	155,495,000.00	153,635,000.00	1,860,000.00	98.8
Тусгай үйл ажиллагааны орлогоо санхүүжилт	8,500,000.00		8,500,000.00	
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	146,995,000.00	153,635,000.00	-6,640,000.00	104.5
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,560,000.00	48,560,000.00		100
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	98,435,000.00	105,075,000.00	-6,640,000.00	106.7
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2019.02.22</b>	Аудитын нэр:	<b>Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: САГ-2019/362/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл Нэр	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Захиргааны хэлтсийн 9 ажилтанд амралтын мөнгө олгоходоо хоол унааны мөнгө 1,323.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.	1,323.0	Төлбөрийн акт тогтоох	Нягтлан бодогч	С.Одончимэг
2	Зөвшөөрөлгүй барьсан барилгыг буулгахад 33,100.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Хан-Уул дүүргийн засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/138 тоот захирамжинд "Газар чөлөөлөх албадан нүүлгэхэд холбогдох зардлыг буруутай этгээдээр төлүүлнэ" гэж тусгасантай нийцэхгүй байна.	33,100.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	С.Одончимэг
	<b>Дүн</b>	<b>34,423.0</b>			



